

МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

2020 он 10 дугаар
сарын 09-ны өдөр

Дугаар Х/786

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР БӨГӨӨД
ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА
Т.ГАНТӨМӨР ТАНАА


Тушаал хүргүүлэх тухай

Шадар сайдын 2020 оны “Усан халаалтын болон уурын зуухыг дэвшилтэт технологид шилжүүлэх тухай” 123 дугаар тушаалыг үүгээр хүргүүлж байна.

Уг тушаалын хэрэгжилтэд өөрийн хариуцсан чиглэлийн дагуу хяналт тавьж, зохих журмын дагуу арга хэмжээ авч ажиллана уу.

Хавсралт: 2 хуудастай.

Шадар сайдын ахлах зөвлөх
бөгөөд Ажлын албаны дарга



С.ЯНЖИНСҮРЭН

2063986



МОНГОЛ УЛС

ШАДАР САЙДЫН ТУШААЛ

20 20 оны 10 дугаар
сарын 08 -ны өдөр

Дугаар 123

Улаанбаатар
хот

Усан халаалтын болон уурын зуухыг дэвшилтэт
технологид шилжүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Засгийн газрын 2018 оны 62 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт технологийн зориулалтаар уур үйлдвэрлэн үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагуудын уурын зуухыг 2021 оны 5 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн, II, III, IV дүгээр цахилгаан станц болон Амгалан, Сэлбэ дэд төвийн дулааны станцаас бусад эрчим хүчний тусгай зөвшөөрөлтэй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын усан халаалтын зуухыг 2022 оны 5 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн тус тус түүхий нүүрс болон хагас боловсруулсан нүүрс түлэхийг хориглосугай.

2. Эрчим хүчний тусгай зөвшөөрөлтэй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын усан халаалтын зуухыг татан буулгаж, төвийн дулаанд холбох, цахилгаан болон хийн түлшний халаалтад шилжүүлэх ажлыг 2022 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн дотор зохион байгуулахыг Сангийн сайд /Ч.Хүрэлбаатар/, Эрчим хүчний сайд /Н.Тавинбэх/, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч /Ж.Батбаясгалан/ нарт тус тус даалгасугай.


3. Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй усан халаалтын болон уурын зуухны хаяг, байршил, зуухны марк нэр төрөл, тоо, зарцуулах түлшний хэмжээ, утааны шүүлтүүртэй эсэх талаарх мэдээлэл агуулсан дэлгэрэнгүй бүртгэл мэдээллээр Мэргэжлийн хяналтын болон Цагдаагийн байгууллагыг хангаж ажиллахыг Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын алба /Т.Гантөмөр/-нд үүрэг болгосугай.

4. Баянзүрх дүүргийн 10, 12, 19 дүгээр хорооны нутаг дэвсгэр дэх түүхий нүүрсээр ажиллах 67 халаалтын зуухны үйл ажиллагааг зогсоож, төвлөрсөн дулааны шугамд холбох ажлын хүрээнд хэрэгжиж буй Цагдаагийн академийн өргөн чөлөөнөөс Гачууртын гудамж хүртэл дулааны шугам барих ажлын зөрүү төлбөр, Газарчин дээд сургууль орчмын ус дулаан дамжуулах төв, инженерийн

шугам сүлжээний хүчин чадлыг өргөтгөх болон Хан-Уул дүүргийн 4 дүгээр хороо, 60, 118 дугаар сургууль, 73 дугаар цэцэрлэгийг төвлөрсөн дулаан хангамжид холбох зэрэг шаардлагатай хөрөнгийг Орчны бохирдол бууруулах Үндэсний хорооноос гаргаж санхүүжүүлэхийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд /Д.Сарангэрэл/, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч /Ж.Батбаясгалан/ нарт үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газар /Т.Гантулга/, Цагдаагийн ерөнхий газар /Ж.Болд/, нэгдсэн удирдлагаар ханган ажиллахыг Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хорооны дарга /Д.Сарангэрэл/, Нийслэлийн Засаг дарга /Ж.Батбаясгалан/ нарт тус тус хариуцуулсугай.

Монгол Улсын Шадар сайд



Я.СОДБААТАР